



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/279

Булган сум

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ой, хээрийн гал түймрийн аюултай үеийг хохирол багатай даван туулах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ой, хээрийн түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, штаб, мэргэжлийн ангиудыг томилон, бэлэн байдлыг хангуулах, ой, хээрийн түймэр унтраах ажлыг шуурхай зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллах шуурхай штабыг Байгаль орчны газар, сумдын Шуурхай штабыг сумын Засаг даргын тамгын газарт байгуулж, 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд томилон ажиллуулсугай.

2.Ой хээрийн гал түймрийн аймгийн шуурхай штабын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах), Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр), бүх шатны шуурхай штабт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг төр, төсвийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4.Аймгийн шуурхай штабт шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэж, Гамшгаас хамгаалах сангаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг), Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч (дэд хурандаа Н.Хишигдорж) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010387

Аймгийн Засаг даргын 2026 оны
дүгээр сарын 20-ны/ний өдрийн
А. (279) дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Шуурхай штабын дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Шуурхай штабын
орлогч дарга: А.Гантөмөр (Байгаль орчны газрын дарга)
Нарийн бичгийн дарга: Б.Отгонжаргал (Байгаль орчны газрын, Ойн
нэгжийн дарга)
Ж.Эрдэнэбулган (Онцгой байдлын газрын Гал
түймрийн хяналтын ахлах байцаагч, ахмад)

1. Ажиллагаа, зохицуулалтын баг:

Багийн ахлагч: Б.Насанжаргал (Аймгийн Засаг даргын тамгын
газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
дарга)
Орлогч: Э.Будсүрэн (Цагдаагийн газрын ахмад)
Гишүүд: Б.Авирмэд (Авто тээврийн төвийн Хяналтын
мэргэжилтэн)
Г.Баярмагнай (Нийгмийн даатгалын хэлтсийн
Нийгмийн хамгааллын улсын байцаагч)
М.Мөнх-Эрдэм ("Булган АЗЗА" ТӨХК-ийн Ерөнхий
инженер)
Б.Золбаяр (Байгаль орчны газрын Байгаль орчны
хяналтын улсын ахлах байцаагч)
М.Хос-Эрдэнэ (Байгаль орчны газрын Байгаль
орчны хяналтын улсын байцаагч)
Б.Ганчимэг (Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)
Ч.Ганчулуун (Мал эмнэлгийн газрын шинжээч)

2. Төлөвлөлтийн баг:

Бүлгийн ахлагч: Г.Галмандах (Онцгой байдлын газрын Гал түймэр
унтраах, аврах 20 дугаар ангийн захирагч, ахлах
дэслэгч)
Гишүүд: С.Алтанзул (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Ц.Цэрэнтогтох (Аймгийн Засаг даргын тамгын
газрын Цэргийн штабын дайчилгааны офицер,
хошууч)
Н.Гансүх (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)
Б.Чулуунцэцэг (Онцгой байдлын газрын

Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ
хариуцсан мэргэжилтэн, дэслэгч)
Б.Алтансүх (Булган сум дундын Ойн ангийн
дарга)
Х.Батжаргал (Цагдаагийн газрын ахмад)
Б.Март (Байгаль орчны газар)

3.Мэдээлэл технологи, харилцаа холбооны баг:

Багийн ахлагч: Б.Баяржаргал (“Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК-
ийн Булган аймаг дахь салбарын дамжуулахын
инженер)
Гишүүд: Г.Содхүү (Ус цаг уур, орчны шинжилгээний
төвийн Холбоо, сүлжээний инженер)
О.Энхбаяр (Булган аймаг дахь Цахим шилжилт
үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн)
Б.Батзориг (Онцгой байдлын газрын 01 дүгээр
ангийн мэргэжилтэн, дэслэгч)
Э.Очирбат (Байгаль орчны газрын мэргэжилтэн)

4.Статистик, судалгаа, дүн шинжилгээний баг:

Багийн ахлагч: Н.Булганбаяр (Статистикийн хэлтсийн
мэргэжилтэн)
Гишүүд: Б.Батболд (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах
байцаагч)
Э.Намуун (Нийгмийн даатгалын хэлтсийн
Хуулийн зөвлөх)
Ц.Энхмаа (Мал эмнэлгийн газрын лабораторийн
шинжээч эмч)
Б.Оюун-Эрдэнэ (Байгаль орчны газрын
мэргэжилтэн)
Б.Хэрлэн (Сум дундын ойн ангийн шинжээч)

5. Нөөц хангалтын баг:

Багийн ахлагч: Ч.Оюун-Эрдэнэчимэг (Аймгийн Засаг даргын
тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт,
бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд: А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газар)
Б.Очирсүрэн (Аймгийн Засаг даргын тамгын
газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн
мэргэжилтэн)
Д.Жигжид (Онцгой байдлын газрын Нягтлан
бодогч, ахлах дэслэгч)
Б.Цогт (Онцгой байдлын газрын 01 дүгээр ангийн
захирагч, ахмад)

Д.Отгонсүрэн (Эрүүл мэндийн газрын Сувилахуй
хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн)

6.Хэвлэл мэдээллийн баг:

Багийн ахлагч:

Э.Эрболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны
дарга)

Гишүүд:

Б.Мөнхбаатар ("Сайхан монгол" телевизийн
захирал)

М.Баттогтох (Онцгой байдлын газрын сургалтын
мэргэжилтэн, дэслэгч)

Д.Дэлгэрмөрөн (Цагдаагийн газрын хошууч)

--o00o--